

**ЗАРИМ ТӨРЛИЙН ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ТҮР ЗОГСООХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ ТӨРИЙН
БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 03 дугаар
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр баталсан бөгөөд уг тогтоолын 4 дүгээр хавсралтад тус бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газраас боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хуулийн төслийн жагсаалтыг баталсан. Уг жагсаалтад Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай хуулийн төслийг боловсруулж, 2022 оны 01 дүгээр сард багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан.

Хууль санаачлагч коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын улмаас эдийн засагт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэхэд төлөвлөгөөт хяналт шалгалтыг түр хугацаанд зогсоох нь бизнес эрхлэгчдэд эерэгээр нөлөөлөх ач холбогдолтой гэж үзэж хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөлд эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх зорилгоор 3 жилийн хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийхгүй бөгөөд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээллээр, эсхүл эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан тохиолдолд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хэвийн хийхээр заасан бөгөөд зөрчил илэрсэн бол тэргүүн ээлжинд зөвлөн туслах, сануулах шинжтэй албан шаардлага хүргүүлэхээр тусгасан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг төслийн 1, 2 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагад ямар байгууллагууд багтах, хуулийн төслийн зохицуулалт нь хуулиар хянан шалгах чиг үүрэг хүлээж буй байгууллагуудын хянан шалгах үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх, хуулийн төслийн хэрэгжих хугацаа, хууль үйлчлэх хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг түр зогсоосноос үүсэх эрсдэл, үр дагаврын талаар, ийнхүү зогсоож хяналт шалгалтыг нөхөн явуулах боломжгүй байдлаас үүссэн үр дагаврыг хэрхэн зохицуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль болон бусад хуулиар хянан шалгах чиг үүрэг хэрэгжүүлдэг үндэсний аудитын байгууллага, Төрийн хяналт шалгалтын хуулийн одоогийн зохицуулалтаар төрийн хяналт шалгалтын тогтолцоонд хамаардаг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц гэх мэт байгууллага болон холбогдох бусад байгууллагын хяналт шалгалт хэлэлцэж буй хуулийн төслийн үйлчлэлд хамаарч байгаа эсэх, хуулийн төслийг нэн яаралтай горимоор хэлэлцэх үндэслэл, шаардлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж төрийн байгууллагаас

бусад аж ахуйн нэгж, иргэн, хуулийн этгээдийн бизнесийн үйл ажиллагаанд төрийн зарим төрлийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох нь цаг үеэ олсон, хувийн хэвшлийг дэмжсэн чухал ач холбогдолтой бодлого болж буй талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил төрийн хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан хяналт шалгалт болгох шинэчлэлийн ажил 2009 оноос эхлэн хэрэгжиж эхэлсэн бөгөөд хууль санаачлагчаас зарим төрлийн хяналт шалгалтыг түр зогсоохдоо салбараар нь болон эрсдэлээр нь ангилсны үндсэн дээр түр зогсоох асуудлыг зохицуулах боломж байсан эсэх, цаашид эрсдэлд суурилсан төлөвлөгөөт хяналт шалгалтыг бэхжүүлэх, төрийн хяналт шалгалтын эрх зүйн орчны давхардал, хийдлийг арилгаж эрх зүйн орчныг ойлгомжтой болгох, хууль үйлчлэх хугацаанд хяналт, шалгалт хийгдээгүйгээс үүссэн хохирлыг хэн, хэрхэн барагдуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд өнгөрсөн хугацаанд хяналт шалгалтаас хэдэн хувь нь төлөвлөгөөт, хэдэн хувь нь төлөвлөгөөт бус хяналт шалгалт байсан, хууль үйлчлэх хугацаанд бизнес эрхлэгчдэд хяналт шалгалтын улмаас учирч буй дарамт хэрхэн буурах талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил төрийн хяналт шалгалттай холбогдох эрх зүйн орчны давхардал, хийдлийг арилгах, эрсдэлийг салбар тус бүрээр ангилах, эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлэхтэй холбоотойгоор 2009-2016 оны хооронд хэрэгжсэн төслийн хэрэгжилт, үр дүнгийн талаар Төрийн байгуулалтын байнгын хороон дээр сонсох, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг зарим төрлийн төрийн хяналт шалгалтыг зогсоохын тулд хууль батлах шаардлага байгаа эсэх, одоо байгаа хуулийн давхардлаа арилгаад явах нь зүйтэй бөгөөд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын түвшинд шийдэх боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг хуулийн төсөл батлагдсанаар төрийн хяналт шалгах чиг үүрэг, тус асуудлыг эрхэлсэн төрийн байгууллагын чадавх буурах, чиг үүрэг алдагдах эрсдэл үүсч болзошгүй талаар, хуулийн төслийн зохицуулалтыг нарийвчлан тогтоох талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд төрийн хүнд суртлыг бууруулах, төрийн албаны бүтээмжийг дээшлүүлэх бодлогын хүрээнд өргөн мэдүүлсэн уг хуулийн төслийг хэлэлцэх нь зүйтэй, хэлэлцүүлгийн шатанд Улсын Их Хурлын гишүүдээс гарсан саналыг хуулийн төсөлд тусгах, төрийн хяналт шалгалтын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь зүйтэй талаар тус тус саналаа илэрхийлсэн болно.

Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 60 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



Ж.МӨНХБАТ